



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/335

Улаанбаатар хот


Г Журам батлах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-гийн "а", 29.2, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ захирамж гарсантай холбогдуулан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам батлах тухай" Нийслэлийн Засаг даргын 2013 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/1146 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

 С.БАТБОЛД

Нийслэлийн Засаг даргын 2017 оны
05-р сарын 21-ны өдрийн
1133-д захирамжийн хавсралт

**НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ,
МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН БҮРДҮҮЛЭХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Хөгжлийн бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг нийслэлийн нутаг дэвсгэрт зохион байгуулах, тэдгээрийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг үнэлж, дүгнэхтэй холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Энэ журмын 1.1-д заасан үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, бусад хууль тогтоомж, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам" болон энэ журмыг дагаж мөрдөнө.

**Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний
зарчим, хамрах хүрээ**

2.1.Энэ журамд заасны дагуу хөгжлийн бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 3.1-д заасан зарчмуудыг баримтална.

2.2.Энэ журмыг нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, нийслэлийн төсөвт болон аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудад мөрдөх бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээний хамрах хүрээнд дараахь бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, үйл ажиллагаа хамаарна:

2.2.1.Улсын Их Хурлын тогтоол;

2.2.2.Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол;

2.2.3.Ерөнхийлөгчийн зарлиг;

2.2.4.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж;

2.2.5.Засгийн газрын тогтоол;

2.2.6.Ерөнхий сайдын захирамж;

- 2.2.7.Засгийн газрын хуралдааны тэмдэглэл;
- 2.2.8.Засгийн газрын албан даалгавар;
- 2.2.9.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон уг хурлын Тэргүүлэгчдийн тогтоол;
- 2.2.10.Нийслэлийн Засаг даргын захирамж;
- 2.2.11.Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдааны тэмдэглэл;
- 2.2.12.Нийслэлийн Засаг даргын албан даалгавар;
- 2.2.13.Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030;
- 2.2.14.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр;
- 2.2.15.бүсчилсэн хөгжлийн бодлого;
- 2.2.16.улсын болон нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ажил;
- 2.2.17.үндэсний хөтөлбөр;
- 2.2.18.улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл;
- 2.2.19.нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт;
- 2.2.20.Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр;
- 2.2.21.нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл;
- 2.2.22.дэд хөтөлбөр;
- 2.2.23.гадаадын зээл, гусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр;
- 2.2.24.эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт;
- 2.2.25.тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан зорилт, арга хэмжээний биелэлт;
- 2.2.26.шилэн дансны хөтлөлт;
- 2.2.27.Засгийн газрын гишүүнээс Нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт;
- 2.2.28.хэрэглэгчийн үнэлгээний тайлан;
- 2.2.29.Нийслэлийн Засаг даргаас харьяа байгууллагын дарга, дүүргийн Засаг дарга нартай байгуулсан үр дүнгийн гэрээний үүргийн биелэлт;

2.2.30.хяналт-шинжилгээний ажлын зөвлөмжийг хэрэгжүүлсэн тайлан.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын удирдлага,
зохион байгуулалт

3.1.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага хариуцсан чиг үүргийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үүрэг бүхий нэгж, эсхүл ажилтантай байна.

3.2.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 4.6-д заасан шаардлага хангасан хүнийг хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх албан тушаалд томилно.

3.3.Нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, шийдвэрийг хэрэгжүүлэх, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг үнэлж дүгнэх ажлыг нийслэлийн хэмжээнд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж, биелэлтэд хяналт тавих, мэдээлэх үүргийг хариуцна.

3.4.Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайланг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 4.4-т заасны дагуу дүүргийн Засаг даргын Тамгын газар, нутгийн захиргааны байгууллагын захиргаа, хүний нөөц, дотоод ажил, эсхүл хяналт шинжилгээ хариуцсан нэгж нэгтгэх бөгөөд түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж, эсхүл ажилтан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүн мэдээг дээд шатны байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

3.5.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайланг тогтоосон хугацаанд үнэн зөв, бодитой гаргаж өгөх үүрэгтэй.

Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан
ажилтны эрх, үүрэг

4.1.Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх албан хаагч нь Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 5.1-д заасан эрх эдэлж, 5.2-т заасан үүрэг хүлээнэ.

Тав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын
төлөвлөлт, арга зүй, хариуцлага

5.1.Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын төлөвлөлт:

5.1.1.нийслэлийн нутгийн захиргааны байгууллага тухайн жилд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын төлөвлөгөөг жил бүр батлах бөгөөд уг төлөвлөгөө нь хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөөний үндсэн хэсэг болно.Төлөвлөгөөнд зорилго, зорилт, хамрах

байгууллага, нэгж, хэрэгжүүлэх хугацаа, зардал, хариуцах эзэн, хамтран оролцох байгууллага, албан тушаалтан зэргийг тусгана;

5.1.2.нийслэл, дүүргийн хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын төлөвлөгөөг тухайн шатны Засаг даргын Тамгын газрын дарга, байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөг байгууллагын дарга /захирал/ тус тус батална;

5.1.3.нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд тогтмол хийх хяналт-шинжилгээний ажлыг хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын төлөвлөгөөнд заасан хугацаанд, шаардлагатай тохиолдолд эрх бүхий удирдлагаас баталсан удирдамжийн дагуу, үнэлгээний ажлыг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актад заасан хугацаанд тус тус гүйцэтгэнэ;

5.1.4.Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 20.1-д заасны дагуу бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэгчийн үнэлгээ хийх ажлыг тус тус тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, шаардагдах зардлыг төсөвт тусган батлуулсан байна;

5.1.5.нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын жилийн үйл ажиллагаанд хийх үнэлгээний ажлыг дараа жилийн I улирлын эхний хагаст багтаан Нийслэлийн Засаг даргын Тамгын газар зохион байгуулна;

5.1.6.Нийслэлийн Засаг дарга шаардлагатай гэж үзвэл нутгийн захиргааны байгууллагын хагас жилийн үйл ажиллагааны явц, үр дүнд хийх үнэлгээг тухайн жилийн гуравдугаар улиралд хийж болно;

5.1.7.нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Нийслэлийн Засаг дарга томилж, ажиллах удирдамжийг батална. Ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн албан хаагч ажиллана.

5.2. Хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын арга зүй:

5.2.1.нийслэлийн хэмжээнд хэрэгжиж байгаа хөгжлийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, шийдвэрийн заалтын хэрэгжилтийг тооцохдоо тайлант хугацааг 100 хувиар тооцож, биелэлтийг 0-100 хувиар үнэлнэ. Үүнд:

-90.0% - 100% Хангалттай;

-50.0% - 89.9% Хэрэгжих шатанд;

-30.0% - 49.9% Хэрэгжилт удаашралтай;

-0.0% - 29.9% Хэрэгжилт хангалтгүй.

Хөгжлийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон дээд шатны байгууллагад

тайлагнахдаа Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6-9 дүгээр бүлэгт заасан аргачлалыг баримтална;

5.2.2.нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ энэ журмын 2 дугаар хавсралтаар баталсан шалгуур үзүүлэлтийг ашиглана;

5.2.3.тухайн жилд шинээр байгуулагдсан болон энэ журамд ажил дүгнэх шалгуур үзүүлэлтүүд нь тусгагдаагүй байгууллагын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх тохиолдолд үнэлгээний ажлын хэсэг шалгуур үзүүлэлтийг нь боловсруулан дүгнэнэ;

5.2.4.нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ хийхээр Нийслэлийн Засаг даргаас томилсон ажлын хэсэг нь байгууллага, нэгжүүдийн үйл ажиллагаанд үнэлгээ хийхдээ энэ журмын 2 дугаар хавсралтаар баталсан үлгэрчилсэн загварыг ашиглах бөгөөд дараахь дэс дарааллыг баримтална:

а/хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамрагдах байгууллагуудаас энэ журмын 8 дугаар бүлэгт заасан аргачлалын дагуу боловсруулж, урьдчилан ирүүлсэн байгууллагын үйл ажиллагааны тайланг судлах;

б/байгууллагын үйл ажиллагааны тайланг судлах явцад зайлшгүй тодруулах, магадлах шаардлагатай асуудлаар газар дээр нь шалгалт хийх.

5.2.5.үлгэрчилсэн загварт заасан үзүүлэлт дээр нэмж, тухайн жилийн зорилтын онцлогтой уялдан оруулсан үзүүлэлтүүд болон нийслэлийн удирдлагаас цаг үеийн асуудлаар өгсөн үүрэг, даалгаврын гүйцэтгэлийн үр дүнг дүгнэхдээ Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс тухайн асуудлаар байгууллага нэгжид өгсөн явцын үнэлгээг суурь үнэлгээ болгон авна.

5.2.6.нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны үнэлгээнд нийт үнэлгээний 40 хувийг бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээний оноо, 40 хувийг байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээний оноо, 10 хувийг байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээний үзүүлэлтийн оноо, 10 хувийг хүний нөөцийн ил тод байдлын үнэлгээний үзүүлэлтийн оноо тус тус эзлэх бөгөөд дараахь томъёогоор тооцоолно:

Шалгуур үзүүлэлт 1 + Шалгуур үзүүлэлт 2 + ... Шалгуур үзүүлэлт n

Дундаж үнэлгээ = $\frac{\text{Шалгуур үзүүлэлт 1} + \text{Шалгуур үзүүлэлт 2} + \dots + \text{Шалгуур үзүүлэлт n}}{n}$

Дундаж Y1 x 40 + Дундаж Y2 x 40 + Дундаж Y3 x 10 + Дундаж Y4 x 10

Ерөнхий үнэлгээ = $\frac{\text{Дундаж Y1} \times 40 + \text{Дундаж Y2} \times 40 + \text{Дундаж Y3} \times 10 + \text{Дундаж Y4} \times 10}{100}$

Зургаа. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын үр дүнтэй холбогдуулан олгох урамшуулал, хүлээлгэх хариуцлага

6.1.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн ерөнхий үнэлгээг дараахь байдлаар ангилна:

Бүрэн хангалттай	90.0-100.0
Хангалттай	80.0-89.9
Ажил сайжруулах шаардлагатай	70.0-79.9
Хангалтгүй	0.0-69.9

6.2.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хийсэн үнэлгээний дүнг үндэслэн дараахь шийдвэрийн төслийг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлнэ:

6.2.1.тухайн жилийн үйл ажиллагааныхаа үр дүнгээр “Бүрэн хангалттай” үнэлгээ авсан байгууллагыг өргөмжлөл, мөнгөн шагналаар, уг мөнгөн шагналын 5 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн шагналаар тухайн байгууллагын удирдлагыг тус тус шагнаж урамшуулахаар;

6.2.2.тухайн жилийн үйл ажиллагааны үр дүнгээр “Ажил сайжруулах шаардлагатай” үнэлгээ авсан, эсхүл өмнөх жилийн хүрсэн түвшнээс ажлын үзүүлэлт нь илт буурсан байгууллага, нэгжийн удирдлагад холбогдох хуульд заасны дагуу сануулах, цалин, хөлсийг бууруулах сахилгын шийтгэл ногдуулахаар;

6.2.3.тухайн жилийн үйл ажиллагааныхаа үр дүнгээр “Хангалтгүй” үнэлгээ авсан бол тухайн байгууллага, нэгжийн удирдлагад холбогдох хуульд заасны дагуу албан тушаал бууруулах, ажлаас чөлөөлөх сахилгын шийтгэл ногдуулахаар.

6.3.Дараахь зөрчил гаргасан албан тушаалтанд Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хуульд заасны дагуу хариуцлага тооцох саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж, шийдвэрлүүлнэ:

6.3.1.Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын төлөвлөгөөний дагуу хийсэн хяналт-шинжилгээний ажлын явцад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны үнэлгээний дүнгээр хоёр удаа хангалтгүй үнэлгээ авсан, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт нь буурсан нутгийн захиргааны байгууллагуудын удирдлагад;

6.3.2.хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын мөрөөр хэрэгжүүлэх зөвлөмжийг биелүүлээгүй нутгийн захиргааны байгууллагуудын удирдлагад;

6.3.3.энэ журмын 8-д заасныг зөрчсөн албан хаагчид;

6.3.4.байгууллагын тайланг дүүргийн Засаг даргын зөвлөл буюу тухайн байгууллагын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлээгүй мэдээлсэн албан хаагчид.

Долоо. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг хэрэгжүүлэх

7.1.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд дурдсан зөвлөмж, дүгнэлтийн дагуу дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

7.1.1.нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын тэргүүний арга, туршлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, гарсан алдаа, дутагдлыг засах;

7.1.2.байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах;

7.1.3.харьяа захиргааны байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх талаар үүрэг, чиглэл өгөх, шаардлагатай тохиолдолд зохих удирдамжийн дагуу газар дээр нь хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргах.

7.2.Нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь хэрэглэгчийн болон хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, сургалт зохион байгуулах, сургалтын материал, ном, товхимол, гарын авлага хэвлүүлэх зэрэг зардлыг жил бүр төсөвтөө тусган батлуулна.

7.3.Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын дүгнэлт, зөвлөмжид үндэслэн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх үүргийг тухайн зорилтын хэрэгжилтийг хариуцсан байгууллага, албан тушаалтан хүлээнэ.

Найм. Тайлан, мэдээ

8.1.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага энэ журмын 1 дүгээр хавсралтаар баталсан хуваарийн дагуу тайлан, мэдээ гаргана.

8.2.Тайлан, мэдээ ирүүлэх хугацааг шаардлагатай тохиолдолд Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас өөрчилж болно. Энэ тохиолдолд албан бичгээр мэдэгдэнэ.

8.3.Шинээр гарсан тогтоол, шийдвэрт биелүүлэх хугацааг заасан тохиолдолд заасан хугацаанд нь, хугацаа тодорхойгүй тохиолдолд гарсан өдрөөс хойш 3 сарын дараагаас эхлэн хэрэгжилтийн явц, үр дүнг тооцно.

8.4.Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 3.2.2-т заасан үндэсний хэмжээнд хэрэгжих бодлогын баримт бичгийн нийслэл хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээний тайлан, мэдээг тухайн арга хэмжээг хамтран хэрэгжүүлэх нийслэлийн холбогдох байгууллагуудаас нэр нь эхэнд бичигдсэн байгууллага нэгтгэн ирүүлнэ.

8.5.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд цаг үеийн шаардлагаар шуурхай мэдээ солилцохдоо цаасан суурьтай мэдээг албан хэрэг хөтлөлтийн журмын дагуу, цахим суурьтай мэдээг хүлээн авагчийн цахим шуудангийн хаягаар тус тус солилцоно.

8.6.Тайлан, мэдээ нь дараахь шаардлагыг хангасан байна:

8.6.1.үйл ажиллагааны гүйцэтгэлийг бүрэн багтаасан, тайлант хугацааг бүрэн хамруулсан байх. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг суурь түвшинтэй уялдуулан зорилтот түвшин, хүрсэн үр дүнг бүрэн тодорхойлж, чанарын болон тоон шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнана;

8.6.2.холбогдох заавар, журмын дагуу боловсруулсан, албан бичиг хэргийн стандартыг хангасан, үг үсгийн болон хэл найруулгын хувьд алдаагүй, тоо баримт зөрөөгүй байх;

8.6.3.нийслэлийн хэмжээнд тухайн чиглэлээр хийсэн ажлыг бүрэн хамруулж, үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлд сэргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлийн үндэслэл, шалтгааныг тодорхой гаргасан байх;

8.6.4.хөгжлийн бодлогын баримт бичгийн уялдаа холбоог хангасан байх;

8.6.5.өмнө хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлтээр өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайланг бүрэн тусгасан байх;

8.6.6.тухайн бодлого, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг нотлох баримт дээр тулгуурлан тодорхойлсон байх бөгөөд шаардлагатай баримт материалыг хавсарган хүргүүлэх;

8.6.7.байгууллагынхаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгжээр мэдээ, тайланд шинжилгээ хийлгэж, баталгаажуулсан байх.

Ес. Байгууллагын хагас болон бүтэн жилийн үйл ажиллагааны тайлангийн бүтэц, агуулга

9.1."Байгууллагын хагас, бүтэн жилийн үйл ажиллагааны тайлан"-г дараахь жишиг загварын дагуу боловсруулсан байна. Үйл ажиллагааны тайлан 5 бүлэгтэй байх бөгөөд бүлэг тус бүр доор дурдсанаар эрэмбэлсэн мэдээллийг агуулсан байна:

9.1.1. Нэгдүгээр бүлэг "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүн":

а/"Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-д заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл;

б/төрөөс баримтлах бодлогод заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл;

в/Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл;

г/улсын болон нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл;

д/бүсчилсэн хөгжлийн бодлогод заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл;

е/үндэсний хөтөлбөрт заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл;

ж/нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтод тусгасан, тухайн байгууллагаас гүйцэтгэх ажлын хэрэгжилт, үр дүнтэй холбоотой мэдээлэл;

з/Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл;

к/нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл;

л/дэд хөтөлбөрт тусгасан, тухайн байгууллагаас гүйцэтгэх ажлын хэрэгжилт, үр дүнтэй холбоотой мэдээлэл;

м/дүүргийн Засаг даргын Тамгын газрын хувьд тухайн дүүргийн дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнтэй холбоотой мэдээлэл;

н/дүүргийн Засаг даргын Тамгын газрын хувьд тухайн дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт, үр дүнтэй холбоотой мэдээлэл.

9.1.2.Хоёрдугаар бүлэг: "Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, үр дүн":

а/Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгавар, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаас тэмдэглэлээр өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилттэй холбоотой мэдээлэл;

б/Нийслэлийн Засаг даргаас тухайн жилд хэрэгжүүлэхээр зарласан зорилтот ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын холбогдолтой мэдээлэл.

9.1.3. Гуравдугаар бүлэг "Байгууллагын үйл ажиллагааны үр дүн":

а/байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн үүргийн хэрэгжилттэй холбоотой мэдээлэл;

б/хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгасан зорилтын хэрэгжилттэй холбоотой мэдээлэл. Энэ мэдээллийг гаргахдаа Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 10 дугаар хавсралтад заасан аргачлалыг баримтална;

в/байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт /KPI/ –ээр үнэлсэн үнэлгээтэй холбоотой мэдээлэл;

г/иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлттэй холбоотой мэдээлэл;

д/бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээлэл;

е/"Нийслэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан"-д тухайн жилд гаргах тайлан, мэдээний тухай мэдээлэл;

ж/дүүргийн Засаг даргын Тамгын газрын хувьд Улаанбаатар хотын "Аз жаргалтай хот" индексийн шалгуур үзүүлэлтүүдийг сайжруулах чиглэлээр зохион байгуулсан ажилтай холбоотой мэдээлэл;

9.1.4.Дөрөвдүгээр бүлэг "Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал":

а/байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилттэй холбоотой мэдээлэл. Энэ мэдээллийг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 11 дүгээр хавсралтад заасан аргачлалыг ашиглана.

9.1.5. Тавдугаар бүлэг "Бусад мэдээлэл":

а/холбогдох чиг үүргийн хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны бусад байгууллагатай ажлын уялдаа холбоог хангах чиглэлээр хамтран ажилласан тухай мэдээлэл;

б/байгууллагын харьяа нэгжүүдийн үндсэн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан тухай мэдээлэл;

в/иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, хүсэлтийн дагуу зохион байгуулсан үйл ажиллагааны талаарх мэдээлэл;

г/хөрөнгө, санхүүжилтийн асуудлаас бусад үндсэн үйл ажиллагаа явуулахад гарч байгаа хүндрэл, бэрхшээл болон цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаарх санал, хүсэлт.

9.1.6.Тайлангийн төгсгөлд тайланг нэгтгэн гаргасан ажилтан, тайлантай танилцаж зөвшөөрсөн байгууллагын дарга нэр, албан тушаалаа бичиж, гарын үсгээ зуран, байгууллагын тамга /тэмдэг/ дарж баталгаажуулсан байх.

9.2.Шаардлага хангаагүй тайлан, мэдээ ирүүлсэн тохиолдолд хүлээн авахаас татгалзаж, энэ тухай байгууллагын удирдлагад мэдэгдэх бөгөөд дахин ирүүлэх хугацааг тогтоож гүйцэтгүүлнэ.

9.3.Тайлан, мэдээ гаргагч байгууллага энэ журмын 9.2-т заасан шалтгаанаар буцаасан тайлан, мэдээг дахин боловсруулах бөгөөд заасан хугацаанд хүргүүлнэ.

9.4.Ирүүлсэн тайлан, мэдээний чанар болон хугацаатай холбогдох хариуцлагыг тухайн байгууллагын удирдлага хариуцна.

9.5.Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс нь тайлан, мэдээ гаргахтай холбоотой асуудлаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.

9.6.Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс нь байгууллагаас ирүүлсэн тайлан, мэдээний боловсруулалтын чанар болон хугацаанд хяналт тавьж, үнэлгээ өгөх бөгөөд энэ үнэлгээ нь тэдгээрийн үйл ажиллагааг дүгнэх шалгуур үзүүлэлтийн харгалзах нэг үзүүлэлт болно.

Арав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан

10.1.Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, захиргааны байгууллагын үйл ажиллагааг үнэлэх, тайлан илгээх, хүлээн авах, мэдээллийн урсгалыг удирдах, хянах, хадгалах, ашиглах, түгээхэд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан (цаашид "цахим сан" гэх)-г ашиглана.

10.2.Цахим сангийн бүрдүүлэлт, ашиглалт, түүнд тавих хяналтыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс хариуцна.

10.3.Бодлогын баримт бичиг, шинээр батлагдан гарсан хууль тогтоомж, шийдвэрийн холбогдох заалтуудыг цахим санд оруулж, хэрэгжилтийг хариуцах байгууллага, албан тушаалтныг үүрэгжүүлэх, биелэлтийг гаргах хугацааг тодорхойлох, биелэлтийн мэдээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс гүйцэтгэнэ.

10.4.Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн гишүүд болон нутгийн захиргааны байгууллагын удирдлага цахим санд өөрийн эрхээр нэвтэрч бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, шийдвэр, түүний хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайлантай танилцаж болно.

10.5.Хэрэгжилтийн тайланг цахим санд оруулахдаа уг тайлан, мэдээг байгууллагын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсний дараа тухайн зорилт, арга хэмжээ, заалтын хүрсэн үр дүнг товч тодорхой бичих бөгөөд шаардлагатай бол нотлох баримтыг файлаар хавсаргана.

10.6.Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн тэмдэглэлийг цаасан суурьтайгаар үйлдэн байгууллагын дарга гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ даран баталгаажуулах бөгөөд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлнэ.

10.7.Цахим санд мэдээлэл оруулж байгаа байгууллага, албан хаагч тухайн мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хариуцна.

---o0o---

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын
үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ
хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх
журмын 1 дүгээр хавсралт

НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДЫН БОДЛОГЫН
БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ,
БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТАЙЛАГНАХ ХУГАЦАА

Тайлан, мэдээний төрөл	Тайлан, мэдээний нэр	Тайлан, мэдээ гаргах байгууллага	Тайлан, мэдээ хүлээн авч нэгтгэх байгуул- лага	Тайлан, мэдээ хүргүүлэх хугацаа	Тайлан, мэдээнд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх байгууллага	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанд дүнг танилцуу- лах хугацаа	Дээд шатны тайлагнах байгууллага, хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Бодлогын баримт бичгийн биелэлт	"Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030" урт хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайлан	Нутгийн захиргааны байгууллагууд	НЗДТГ-ын БТХ	(2 жил тутам)	НЗДТГ-ын ХШҮХ	-	Үндэсний хөгжлийн газар (тодорхойгүй)
	Бүсчилсэн хөгжлийн бодлогын хэрэгжилт	Нутгийн захиргааны байгууллагууд	НЗДТГ-ын БТХ	09.05	НЗДТГ-ын ХШҮХ	09.20	Үндэсний хөгжлийн газар 10.01
	Төрөөс баримтлах бодлогын хэрэгжилт	Нутгийн захиргааны байгууллагууд	НЗДТГ-ын БТХ	12.20	НЗДТГ-ын ХШҮХ	01.15	Холбогдох ям 02.01
	Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажил- лагааны хөтөлбөрийн хэрэгжилт	Нутгийн захиргааны байгууллагууд	НЗДТГ-ын ХШҮХ	01.05 06.05	НЗДТГ-ын ХШҮХ	01.25 06.25	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар 02.01 07.01
	Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт	Нутгийн захиргааны байгууллагууд	НЗДТГ-ын ХШҮХ	12.20	НЗДТГ-ын ХШҮХ	02.01	Холбогдох ям 02.10
	"Эдийн засгийг сэргээх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх нарийвчилсан тоололгооны биелэлтийн мэдээ	НЗДТГ-ын хэлтсүүд	НЗДТГ-ын БТХ	Сар бүрийн 04-ны дотор	-	-	Сангийн яам Сар бүрийн 05
	Монгол Улсын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт	Нутгийн захиргааны байгууллагууд	НЗДТГ-ын ХШҮХ	12.15 05.20	НЗДТГ-ын ХШҮХ	12.25 06.10	ЭЗХЯ 01.10 06.15
	Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажил- лагааны хөтөлбөрийн	Нутгийн захиргааны байгууллагууд	НЗДТГ-ын ХШҮХ	01.05 06.05 10.15	НЗДТГ-ын ХШҮХ	02.15 09.10	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба Засгийн

	хэрэгжилт						газрын Хэрэг эрхлэх газар 02.20 11.10
	Дэд хөтөлбөрийн хэрэгжилт	Нутгийн захиргааны байгууллагууд	НЗДТГ-ын ХШҮХ	01.05	НЗДТГ-ын ХШҮХ	01.20	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба 02.10 Засгийн газрын Хэрэг эрхлэх газар 02.20
	Нийслэлийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт /тухайн жил/	Нутгийн захиргааны байгууллагууд	НЗДТГ-ын ХШҮХ	04.05 06.05 09.15	НЗДТГ-ын ХШҮХ	04.20 10.01	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба Засгийн газрын Хэрэг эрхлэх газар 02.20 10.05
	Нийслэлийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт /өмнөх жил/	Нутгийн захиргааны байгууллагууд	НЗДТГ-ын ХШҮХ	01.15 09.15	НЗДТГ-ын ХШҮХ	02.15 10.01	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба Засгийн газрын Хэрэг эрхлэх газар 02.20 10.05
	Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон дэд хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт	Дүүргүүд	НЗДТГ-ын ТЗҮХ	01.20	-	-	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба 02.01
Тогтоол шийдвэр, удирд- лын анх гаргасан шийд- вэрийн биелэлт	УИХ-ын тогтоол, УИХ-ын Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн нийслэлд холбогдолтой заалтуудын хэрэгжилтийн тайлан	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд /Байгууллагын даргын зөвлөлийн хурлаараа хэлэлцүүлсний дараа "Lmonitoring" программд мэдээг оруулна. Байгууллагын даргын зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийг цаасан суурьтайгаар албажуулж хүргүүлнэ./	НЗДТГ-ын ХШҮХ	03.25 06.25 09.25 12.25	НЗДТГ-ын ХШҮХ	01.15 07.01	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар 01-р сарын 15 07-р сарын 01

	Засгийн газраас батлан хамгаалахын чиглэлээр гаргасан тогтоолын биелэлтийн тайлан	Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб	НЗДТГ-ын Цэргийн штаб	06.01 12.01	-	-	Батлан хамгаалах яам 06.15 12.15
	НИТХ-ын болон Тэргүүлэгчдийн тогтоолын хэрэгжилтийн тайлан	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд /Байгууллагын даргын зөвлөлийн хурлаараа хэлэлцүүлсний дараа "Lmonitoring" программ-д мэдээг оруулна. Байгууллагын даргын зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийг цаасан суурьтайгаар албажуулж хүргүүлнэ./	НЗДТГ-ын ХШҮХ	03.25 06.25 09.25 12.25	НЗДТГ-ын ХШҮХ	01.10 04.10 07.10 10.10	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба Жил бүрийн 01-р сарын 20 04-р сарын 20 07-р сарын 20 10-р сарын 20
	Нийслэлийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтийн тайлан	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд /Байгууллагын даргын зөвлөлийн хурлаараа хэлэлцүүлсний дараа "Lmonitoring" программ-д мэдээг оруулна. Байгууллагын даргын зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийг цаасан суурьтайгаар албажуулж хүргүүлнэ./	НЗДТГ-ын ХШҮХ	Сар бүрийн 05-ны дотор	НЗДТГ-ын ХШҮХ	01.10 04.10 07.10 10.10	-
	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийн тайлан	Нийслэлийн тер, захиргааны байгууллагууд /Байгууллагын даргын зөвлөлийн хурлаараа хэлэлцүүлсний дараа "Lmonitoring" программ-д мэдээг оруулна. Байгууллагын даргын	НЗДТГ-ын ХШҮХ	Сар бүрийн 05-ны дотор	НЗДТГ-ын ХШҮХ	сар бүрийн 10	-

		зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийг цаасан суурьтайгаар албажуулж хүргүүлнэ./					
	Нийслэлийн Засаг даргын албан даалгаврын хэрэгжилтийн тайлан	Нийслэлийн төр, захиргааны байгууллагууд /Байгууллагын даргын зөвлөлийн хурлаараа хэлэлцүүлсний дараа "Lmonitoring" программ-д мэдээг оруулна. Байгууллагын даргын зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийг цаасан суурьтайгаар албажуулж хүргүүлнэ./	НЗДТГ-ын ХШҮХ	Сар бүрийн 05-ны дотор	НЗДТГ-ын ХШҮХ	сар бүрийн 10	-
	ЗГ-ын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хэрэгжилтийн тайлан	Дүүргүүд	НЗДТГ-ын БТХ ТЗУХ СТСХ	01.05 07.05		-	Салбарын яамдад 01.25 07.25
	Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн дээр өгсөн үүргийн биелэлтийн мэдээ	Нутгийн захиргааны байгууллагууд	Сайтад байршуулна	Шуурхай зөвлөгөөний өмнөх 7 хоногийн пүрэв гариг	НЗДТГ-ын ХШҮХ	Улирал бүрийн эхний сард	-
Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны мэдээ	Нийслэлийн Засаг дарга түүний Тамгын газрын тухайн жилийн үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээний тайлан	НЗДТГ-ын ТЗУХ	НЗДТГ-ын ТЗУХ	02.01	НЗДТГ-ын ХШҮХ	03.20	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар 04.01
	Байгууллагын хагас, бүтэн жилийн үйл ажиллагааны тайлан	Нутгийн захиргааны байгууллагууд	НЗДТГ-ын ХШҮХ	01.05 07.01	НЗДТГ-ын ХШҮХ	02.10 08.10	
	Төсвийн ерөнхийлөн захирагч нийслэлийн Засаг даргаас Нийслэлийн нутгийн захиргааны болон Захирагчийн харьяа байгуул-	Нутгийн захиргааны байгууллагууд	НЗДТГ-ын ХШҮХ	01.05 07.01	НЗДТГ-ын ХШҮХ	02.10 08.10	-

лагуудын дарга, эрхлэгч нартай байгуулсан "Үр дүнгийн гэрээ"-ний биелэлтийн тайлан						
Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын нэгдсэн тайлан	Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төв	НЗДТГ-ын ТЗУХ	04.01 07.01 10.01 01.01	НЗДТГ-ын ХШҮХ	07.05 02.05	-
Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан	Нутгийн захиргааны байгууллагууд	НЗДТГ-ын ТЗУХ	01.05	-		ТАЗ 01.17
Төрийн албан хаагчдын ёс зүйн зөрчлийн мэдээ	Нутгийн захиргааны байгууллагууд	НЗДТГ-ын ТЗУХ	01.01 07.01			ТАЗ 01.15 07.15
Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн тайлан	Нутгийн захиргааны байгууллагууд	НЗДТГ-ын ТЗУХ	01.15			АТГ 01.20
Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын ХАСХОМ-ийн мэдүүлэг гаргах албан тушаалтны нэрсийн жагсаалт	Нутгийн захиргааны байгууллагууд	НЗДТГ-ын ТЗУХ	01.05	-		АТГ 01.15
ХАСХОМ-ын тайлан	Нутгийн захиргааны байгууллагууд	НЗДТГ-ын ТЗУХ	02.01	-		АТГ 03.01
Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг зохион байгуулсан ажлын тайлан	Нутгийн захиргааны байгууллагууд	НЗДТГ-ын ТЗУХ-ийн НҮНТ	Улирал бүрийн сүүлийн сарын 30-ны өдрийн дотор	НЗДТГ-ын ХШҮХ	01.05 07.05	-
Удирдлагуудын иргэдтэй хийсэн уулзалтын тайлан	Нутгийн захиргааны байгууллагууд	НЗДТГ-ын ТЗУХ-ийн НҮНТ	Улирал бүрийн сүүлийн сарын 30-ны өдрийн дотор	НЗДТГ-ын ХШҮХ	01.05 07.05	
Нийслэлд эзэл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн тухай мэдээ	Нутгийн захиргааны байгууллагууд	НЗДТГ-ын БТХ ТХХАТ	05.10	НЗДТГ-ын ХШҮХ	05.20	-
Албан бичгийн шийдвэрлэл-	Нутгийн захиргааны	НЗДТГ-ын ТЗУХ-ийн	Улирал бүрийн	НЗДТГ-ын ХШҮХ	01.05 07.05	-

тийг зохион байгуулсан ажлын тайлан	байгууллагууд	НҮНТ	сүүлийн сарын 30-ны өдрийн дотор			
Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээ /Холбогдох журмын дагуу/	НХОГ, НАЗХГ, НХААГ дүүргүүд болон эрх шилжсэн байгууллагууд	НЗДТГ-ын СТСХ, БТХ, НХААГ	Сар бүрийн 5-ны дотор	НЗДТГ-ын ХШҮХ	06.10 11.10	Сангийн яаманд сар бүрийн 5-ны дотор, холбогдох яаманд сар бүрийн 5-ны дотор
Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлтийн мэдээ	Нутгийн захиргааны байгууллагууд /Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 10 дугаар хавсралтаар баталсан хүснэгтийн дагуу/	НЗДТГ-ын ТЗУХ	Хагас, бүтэн жилээр	НЗДТГ-ын ХШҮХ	Хагас, бүтэн жилээр	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар 04.01
Засгийн газрын гишүүд, салбарын сайд нартай байгуулсан батламж, санамж бичиг, хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийн мэдээ	Засгийн газрын гишүүд, салбарын сайд нартай байгуулсан батламж, санамж бичиг, хамтран ажиллах гэрээний хэрэгжилт хариуцсан нутгийн захиргааны байгууллагууд	НЗДТГ-ын хэлтсүүд	03.10	НЗДТГ-ын ХШҮХ	03.25	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Холбогдох яам 04.01
Батлан хамгаалахын сайдын Нийслэлийн Засаг даргатай байгуулсан "Санамж бичиг"-ийн хэрэгжилт	Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб	НЗДТГ-ын Цэргийн штаб	06.01 12.01	-	-	Батлан хамгаалах яам 06.15 12.15
Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ	Дүүргүүд, ТЕЗ-н шууд харьяаны байгууллагууд	НЗДТГ-ын СТСХ	Сар бүрийн 4-ний дотор Сар бүрийн	-	-	Сангийн яаманд сар бүрийн 8-ны дотор

				2-ны дотор			
Төсвийн гүйцэтгэл, санхүүгийн хагас жил, бүтэн жилийн тайлан	Дүүргүүд, ТЭЗ-н шууд харьяаны байгууллагууд	НЗДТГ-ын СТСХ	02.25 07.15	-	-	Сангийн яаманд 03.25 07.25	
Төсвийн гүйцэтгэл, санхүүгийн улирлын тайлан	ОНӨҮГ-ууд	НЗДТГ-ын СТСХ	Улирлын санхүүгийн тайланг дараа сарын 10-ны дотор, жилийн санхүүгийн тайланг дараа оны 2 сарын 10-ны дотор	-	-	Сангийн яаманд 03.25 07.25	
Улсын төсвийн байгууллагад олгосон санхүүжилтийн эрхийн тооцоо	Дүүргүүд	НЗДТГ-ын СТСХ	Хагас, бүтэн жилээр	-	-	Сангийн яам болон холбогдох бусад яаманд 07.10 01.10	
Торгууль, шийтгэврийн хуудасны тооцоо	-	НЗДТГ-ын СТСХ	-	-	-	Сангийн яаманд 06.30 01.15	
Засгийн газрын санхүү удирдлагын мэдээллийн системийн хэрэглэгчдийн судалгаа	Дүүргүүд	НЗДТГ-ын СТСХ	Улирал бүрийн сүүлийн сарын 10-ны дотор	-	-	Сангийн яаманд улирал бүрийн сүүлийн сарын 15-ны дотор	
Төрийн санд хэрэглэгдэж байгаа тамга тэмдгийн судалгаа	Дүүргүүд	НЗДТГ-ын СТСХ	1.05	-	-	Сангийн яаманд 01.10	
Эдийн засаг, санхүүгийн шуурхай мэдээллийн үзүүлэлтүүд /Нийслэл дэх ажлын байр, хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүд/	Хөдөлмөр эрхлэлтийн газар	НЗДТГ-ын НБХ	7 хоног бүрийн Пүрэв гариг	-	Нийслэлийн удирд- лагуудад танилцуу- лах Тухай бүрт	-	
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажлын тайлан	Улаанбаатар хотын цагдаагийн газар, Замын цагдаагийн газар	НЗДТГ-ын ХЭЗХ	06.20 12.10	НЗДТГ-ын ХШҮХ	-	ХЗДХЯ 07.10 12.20	
Эрх зүйн ажлын тайлан	Нутгийн захиргааны байгууллагууд	НЗДТГ-ын ХЭЗХ	06.20 12.10	-	-	ХЗДХЯ 07.10 12.20	
ХЗДХ-ийн сайдтай байгуулсан гэрээний тайлан	Холбогдох нутгийн захиргааны байгууллагууд	НЗДТГ-ын ХЭЗХ	06.20 12.10	-	-	ХЗДХЯ 07.10 12.20	
Шүүхэд	Нутгийн	НЗДТГ-ын	06.20	-	-	-	

төлөөлсөн байдал, хянан шийдвэрлэгдсэн хэрэг маргааны тайлан	захиргааны байгууллагууд	ХЭЗХ	12.10			
Гадаад харилцааны үйл ажиллагааны тайлан	Нутгийн захиргааны байгууллагууд	НЗДТГ-ын ГХХ	06.20 12.20	-	-	ГХЯ 02.01
Улаанбаатар хотоос Москва, Сөүл, Эрзэн хотуудад суугаа төлөөлөгчдийн газрын хагас, бүтэн жилийн тайлан	Улаанбаатар хотоос гадаад орнуудад суугаа төлөөлөгчид	НЗДТГ-ын ГХХ	-	-	-	ГХЯ 06.25 12.25
Гадаад улс оронд албан томилолтоор ажилласан тухай тайлан	НЗД-ын захирамжаар Гадаад улс оронд зорчсон албан хаагчид	НЗДТГ-ын ГХХ	Ажлын 7 өдрийн дотор	-	06.25 12.25	-
Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын сарын үйл ажиллагааны тайлан, мэдээ, дараа сарын хийх ажлын төлөвлөгөө	Нутгийн захиргааны байгууллагууд /Цахим суурьтайгаар хүргүүлнэ./	НЗДТГ-ын ХШҮХ	Сар бүрийн 05-ны дотор	НЗДТГ-ын ХШҮХ	-	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба Сар бүрийн 10
Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх сэтгэл ханамжийн судалгааны тайлан	ДЗДТГ	НЗДТГ-ын ХШҮХ	02.01-ний дотор	НЗДТГ-ын ХШҮХ	03.23	-
Удирдлагуудын иргэдтэй хийсэн уулзалтын тайлан	Нутгийн захиргааны байгууллагууд	НЗДТГ-ын ТЗҮХ-ийн НҮНТ	Улирал бүрийн сүүлийн сарын 30-ны өдрийн дотор	НЗДТГ-ын ХШҮХ	01.05 07.05	-

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын
үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ
хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх
журмын 2 дугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР

Үзүүлэлтүүд		Хувь	Жин	Оноо
1	2	3	4	5
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1.Хууль тогтоомж, шийдвэрт нийслэл хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан заалтуудын хэрэгжилт /Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан журмын 01 дүгээр хавсралтад заасан аргачлалаар тооцно/		0.4	
	2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд нийслэл хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж зохион байгуулсан байдал. Улсын төсөв, зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл, чанар, үр дүн /Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан журмын 03, 04 дүгээр хавсралтад заасан аргачлалаар тооцно/			
	3.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг тухайн онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж зохион байгуулсан байдал. Нийслэлийн төсөв, зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл, чанар, үр дүн /Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан журмын 02 дугаар хавсралтад заасан аргачлалаар тооцно/			
	4.Нийслэлийн Засаг даргаас Засгийн газрын гишүүд, салбарын сайд нартай байгуулсан батламж, санамж бичиг, хамтран ажиллах гэрээнд заасан зорилтуудын хэрэгжилт, чанар, үр дүн			
	5.Нийслэлийн Засаг даргаас тухайн жилд дэвшүүлсэн зорилтын хүрээнд хийсэн ажлын гүйцэтгэл, чанар, үр дүн			
Хэсгийн дундаж хувь				
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1.Дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт буюу байгууллагын үйл ажиллагааны үр дүнг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт /KPI/-ээр үнэлсэн үнэлгээний дүн		0.4	
	2.Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгасан зорилтын биелэлт /Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан журмын 10 дугаар хавсралтад заасан аргачлалаар тооцно			
	3.Архив, албан хэрэг хөтлөлт, хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн байдал			
	4.Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал			
	5.Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх талаар хэрэгжүүлж байгаа ажил, үр дүн			
	6.Байгууллагын үйл ажиллагаанд дотоод удирдлагын программ нэвтрүүлсэн байдал			

	7.Байгууллагын үйл ажиллагааны зардал хямдруулах, төсөв хэмнэх чиглэлээр зохион байгуулж, үр дүнд хүрсэн бодитой ажил		
	8.Өмнөх жилийн үр дүнг үнэлсэн ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийн дагуу хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлсэн байдал		
	Хэсгийн дундаж хувь		
Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ	1.Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчилсэн байдал		
	2.Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангасан байдал буюу шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ		
	3.Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчилсэн байдал;		
	4.Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчилсэн байдал;		
	5.Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчилсэн байдал;		
	6.Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгасан байдал;	0.1	
	7.Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байдал;		
	8.Төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлсэн байдал;		
	9.Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчилсэн байдал;		
	10.Улсын болон нийслэлийн төсвийн хөрөнгөөр болон гадаадын эзэл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдал, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчилсэн байдал;		

Хэсгийн дундаж хувь				
Хүний нөөцийн ил тод байдлын үнэлгээ	1.Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарласан байдал;		0.1	
	2.Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчилсэн байдал;			
	3.Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчилсэн байдал;			
	4.Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлсэн байдал;			
	5.Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлсэн байдал;			
Хэсгийн дундаж хувь				
Ерөнхий үнэлгээ			1.0	